

МОНГОЛ УЛС ДАХЬ ОРОС СУДЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЗОРИЛТ

Д.АЛТАЙ
Доктор (Ph.D), профессор
Төв, Зүүн Европ судлалын
Монголын Холбооны Тэргүүн

Хураангуй: Энэхүү илтгэлд ХХ зууны 1921-1990 онд хөгжсөн Зөвлөлт судлалын зарим онцлог, 2000 оноос хойших үеийн Монголын Орос судлалын өнөөгийн байдал, үндсэн чиглэлийг судлан авч үзжээ. Түүнчлэн Орос судлалын чиглэлээр ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарт хийгдсэн судалгаа, ном бүтээлийн тойм, Орос судлалтай холбоотой бусад ажлыг түүхчлэн харуулсан байна. Улмаар Монголын Орос судлалыг цаашид эрчимтэй хөгжүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ, тулгамдсан зорилтын тухай саналаа тодорхой өгүүлжээ.

Түлхүүр үгс: Зөвлөлт судлал, Орос судлал, стратегийн түншлэлийн харилцаа, “хөрш” орны хэмжүүр, суурь судалгааны төсөл, хамтарсан грант

Нэг. Орос судлал: Түүхэн өмнөтгөл

1990-ээд оноос өмнөх социалист бүтээн байгуулалтын жилүүдэд Зөвлөлт судлал, түүн дотроо Монгол-Зөвлөлтийн харилцаа, хамтын ажиллагаа зэрэг нийгэм-улс төрийн хүрээний судалгааг МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн Институтэд (хожим Нийгмийн Ухааны Институт гэж нэршсэн) хариуцан хийж байв. Харин иргэний түүхийн судалгааг ШУА-ийн Түүхийн Хүрээлэн, Дорно дахин судлалын хүрээлэн (эдүгээ ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн) зэрэг эрдэм шинжилгээний байгууллагад эрхлэн гүйцэтгэж байжээ. Үүнд хөрш хоёр улс болох ЗСБНХУ ба БНХАУ-ын талаарх судалгаа, Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны тулгамдсан асуудлууд, БНМАУ-ын капиталист бус хөгжлийн зам, “гурав дахь ертөнцийн” орнуудын (Ази Африкийн тусгаар тогтнолоо шинээр тунхагласан орнуудыг) асуудлыг анхааран судалж байжээ.

Энэ үеийн Зөвлөлт судлал дараах үндсэн чиглэлд төвлөрч байв. Үүнд:

- 1905-1907 оны Оросын хувьсгал, 1917 оны Октябрийн хувьсгал ба түүний Дорно дахинд ялангуяа Монголд үзүүлсэн нөлөө
- БНМАУ ба ЗСБНХУ-ын хоорондын ах дүүгийн найрамдалт харилцаа, Монгол-Зөвлөлтийн хамтын ажиллагаанд МАХН, ЗХУКН-ын гүйцэтгэсэн үүрэг

- Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх, хөгжлийн үе шат, хоёр орны эдийн засаг-худалдаа, соёл-шинжлэх ухааны салбарын харилцаа, хамтын ажиллагаа
- Монгол-Зөвлөлтийн цэрэг, улс төрийн хүрээний хамтын ажиллагаа, Халх голын байлдаан ба дэлхийн хоёрдугаар дайны шувтаргын Чөлөөлөх дайнд хамтран тэмцсэн тухай зэрэг асуудалд төвлөрч байв.

Октябрийн болон Монгол ардын хувьсгалын түүхэн тэмдэглэлт ой, Улс тунхагласны баярыг тохиолдуулан эрдэм шинжилгээний бага хурал хамтран зохиох, БНМАУ-ын капиталист бус хөгжлийн замын түүхэн туршлага, олон улсын коммунист ажилчны хөдөлгөөнийг бэхжүүлэхэд ЗХУКН ба МАХН-ын оруулсан хувь нэмэр зэрэг асуудлаар хамтын томоохон бүтээл туурвин орос, монгол хэлээр хэвлүүлж байжээ.

ЗХУ-ын гадаад, дотоод бодлогыг Монголын ард түмэнд ойлгуулан сурталчлах зорилгоор ЗХУКН-ын их хурал, Төв Хорооны бүгд хурлын тогтоол, шийдвэр, Зөвлөлтийн нам, төрийн удирдагчдын хэлсэн үг, илтгэлийг монгол хэлнээ хөрвүүлэн хэвлэж нийтийн хүртээл болгож байлаа. Албан байгууллагуудад зохиогддог өглөөний сонсголоор эдгээр сэдвээр мэдээлэл хийх ажлыг орон даяар зохион байгуулж, ухуулга сурталчилгаа, үзэл суртлын гол хэрэгсэл болгож байсан юм.

Энэ байдлаас харахад Зөвлөлт судлал нь улс төрийн агуулгатай, ертөнцийг үзэх марсист-ленинист үзэл санаанд тулгуурласан үзэл суртлын шинж чанартай байсан нь тодорхой. Тиймээс ч судалгааны зохиол бүтээл нь тухайн цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн байр сууринаас бичигдсэн байдаг. Манай ахмад үеийн түүхчид, нийгмийн шинжлэх ухааны судлаачид дээр дурдсан асуудлаар судалгаа хийж, олон тооны ном бүтээл, зохиолыг туурвин гаргасан ба тэдгээрийн агуулга, ач холбогдлыг бүхэлд нь үгүйсгэх нь учир дутагдалтай. Тэдгээр нь манай улсын туулж өнгөрүүлсэн түүхэн замналын тусгал байсан гэж хэлж болно. ЗХУ-д хандах, судлах асуудал нь “үзэл санаа, зорилго нэгтэй” ах дүүгийн оронд хандсан тухайн цагийн үзэл суртлын онцлог агуулгаар тодорхойлогдож байв. Тэр цагт ЗХУ нь Монгол орны хувьд үлгэр дууриал, социалист хамтын нөхөрлөлийн манлайлагч улс байсан төдийгүй БНМАУ-ын нийгмийн амьдралын бүхий л хүрээнд туслалцаа дэмжлэг үзүүлдэг дотны “холбоотон” улс байлаа. Зөвлөлт судлал нь хоёр улсын хоорондын харилцаа, нийгмийн амьдралын бүхий л хүрээний хамтын ажиллагаа, ЗСБНХУ-аас БНМАУ-д үзүүлж байсан “ах дүүгийн тусламж” зэрэг хязгаарлагдмал агуулгын хүрээнд хийгдэж, харин үнэн бодитой судалгаа хийх боломж нэн хязгаарлагдмал байсан. Тухайн цаг үед эрдэм шинжилгээ судалгааны ажил нь албан ёсны үзэл суртлын нөлөөн дор хийгдэж, улс төрийн бодлогоо зөвтгөх нэг ёсны хэрэгсэл болж байв. Энэ үед хаалттай сэдэв буюу улс төрийн хэлмэгдүүлэлт, нэг хүнийг тахин шүтэх явдал зэрэг асуудлыг сөхөж ярих, судалж бичих явдал хориотой байсан бөгөөд түүний аливаа оролдлого, илрэлийг намын эсрэг үйл ажиллагаа гэж үзэн шүүмжилж байжээ.

1960-аад оны эхээр Монголын сэхээтний зарим төлөөлөл Бүгд Найрамдах Монгол Ард Улс нь социализм байгуулах зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлэхдээ үндэсний онцлогоо харгалзахгүй байгаа тухай саналаа хэлэх болсон байна. ЗХУ-ыг даган дуурайж, өөрийн орны ялгаатай байдал, хөгжлийн онцлогийг үл харгалзан Зөвлөлтөд авч хэрэгжүүлж буй нийгэм-эдийн засгийн арга хэмжээг шууд хуулбарлаж буйг тэд шүүмжилж байлаа. Энэ санал шүүмжлэлийг МАХН-ын удирдлагын зүгээс намын эсрэг байр суурь, “сэхээтний төөрөгдөл” гэж нэрлэн, тэдгээр хүмүүсийг албан тушаалаас нь өөрчилж, нутаг заан явуулах зэргээр шийтгэсэн байдаг. Зөвлөлт оронд хэрэгжүүлж буй бодлогыг хуулбарлаж, Коминтерн, Зөвлөлтийн удирдагчдын заавраар улс төрийн хэлмэгдүүлэлтийг хийж, нэг хүнийг тахин шүтэх явдлын хор уршгийн гашуун сургамжийг манай ард түмэн өмнө ч амсаж ирсэн билээ. Эдгээр үйл явдлын гэрч болсон ахмад түүхчид, нийгэм судлаачдад зөвшөөрөгдсөн үзэл суртлын хүрээнд л судалгаа хийх ёстой гэсэн ойлголт хандлага төлөвшсөн байхыг үгүйсгэх аргагүй.

Ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэнээр Монголын нийгмийн оюун санааны ухамсарт гүнзгий өөрчлөлтүүд гарч, түүхийн үйл явцыг шинжлэхдээ үзэл сурталжсан хандлагаас татгалзах болов. Нийгэм улс төрийн судалгаанд хөгжлийн шинэ үе эхэлж, түүхийн асуудлыг бодитой, олон талт дүн шинжилгээнд тулгуурлан судлах арга зүй нэвтэрч эхлэв. 1990- ээд оны дундуур өмнө нь хаалттай байсан Монгол-Оросын харилцааны ээдрээтэй асуудалд хамаарах архивын баримт бичгүүдийг Оросын тал Монгол Улсад хүлээлгэн өгсөн нь түүх судлаачдад өргөн боломжийг олгосон байна.

Хоёр. Монголын Орос судлалын өнөөгийн байдал

Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн 138 тоот тогтоолоор ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэн сэргээн байгуулагдсанаар Орос судлал, Хятад судлал, Япон судлал зэрэг бие даасан салбарууд бий болох үндэс суурь тавигдаж, Орос судлал судалгааны түвшинд хөгжих бололцоо нээгдсэн байна. Ингэснээр шинжлэх ухааны судалгаа хийх эрх зүйн орчин шинэчлэгдэж, суурь судалгааны сэдэвт ажил, төсөл, хамтарсан грант төслүүд хэрэгжиж эхлэв.

Энэ үед Орос судлалын чиглэлээр 3 жилийн хугацаатай суурь судалгааны сэдэвт ажил, хамтарсан грантын төслийг хэрэгжүүлж, үр дүнд нь нэг сэдэвт хамтын бүтээл, эмхэтгэл хэвлэгдэж, эрдэм шинжилгээний хурал болон семинарт илтгэл хэлэлцүүлж, олон арван эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдэх болов. Улмаар судалгааны арга зүй болон хүний нөөцийн чадавхи бүрэлдэж төлөвшсөн юм. Ийнхүү ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд 2000 оноос Орос судлал нь бие даасан салбарын түвшинд төлөвшин хөгжиж, эдүгээ 10 гаруй мэргэшсэн судлаачидтай болсон байна.

Орос судлалын салбарт ОХУ-ын орчин үеийн түүхийг олон улсын харилцаа-орон судлалын хүрээнд судлах эхлэл тавигдаж, Оросын дотоод, гадаад бодлогын

өөрчлөлт, түүний Монгол оронд хэрхэн нөлөөлж буй болон Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагаа зэрэг асуудлаар судалгаа хийж эхэлсэн байна. Түүнчлэн Монгол орны гадаад улс төр-эдийн засгийн бодлого, олон улсын болон бүс нутгийн түвшинд ОХУ-ын үзүүлэх нөлөөний асуудлыг ч анхааран судлах болжээ.

Орос судлалын судалгааны үндсэн чиглэлүүд гэвэл:

- ОХУ-ын дотоод, гадаад бодлогын тулгамдсан зорилтууд
- Монгол-Оросын харилцаа: түүх, өнөөгийн байдал, ирээдүйн хандлага ба Монгол-Оросын стратегийн түншлэлийн шинэ зорилт ба сорилтууд
- Даяаршилын нөхцөл дахь олон тулгуурт олон улсын харилцаа ба ОХУ-ын түүнд үзүүлэх нөлөө, байр суурь, үүрэг оролцоо
- ОХУ, Монгол, БНХАУ-ын хооронд Эдийн засгийн коридор байгуулах үйл явцад оролцох боломж, хамтын ажиллагааны төлөв зэргийг дурдаж болно.

Тухайлбал Орос судлалын хүрээнд 1990-ээд оны дундуур ОХУ-д амьдарч байсан монгол хэл, соёлт үндэстний түүх, Монгол-Орос, Монгол-Хятадын харилцаа, ОХУ-ын Ази, Номхон далайн бүсэд баримтлах гадаад бодлого зэрэг асуудлаар судалгаа хийгдсэн байна. Үр дүнгээр нь Орос судлалын анхны эрдэм шинжилгээний товхимол¹, нэг сэдэвт зохиолууд² нийтийн хүртээл болж, тэдгээрт судалгааны шинэ хандлага, арга зүйг ашиглажээ. Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны чиглэлд орхигдож байсан хоёр улсын бүс нутгийн хамтын ажиллагаа, ОХУ-ын бүс нутгийн хөгжлийн асуудлаар хамтарсан судалгаа хийж ном, бүтээл³ хэвлэгдэн гарах болов. Мөн энэ үед хэвлэгдсэн зарим судлаачдын нэг сэдэвт бүтээлд⁴ Монголын улс төрийн бодлогод олон улсын гадаад орчны үзүүлсэн нөлөө, хүчин зүйлийн асуудлыг судлан шинжилсэн нь сонирхол татахуйц шинэлэг ажил болсон. Тухайлбал, Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын асуудлаар Орос, Хятадын хандлага, байр суурь хэрхэн өөрчлөгдсөнийг задлан шинжилсэн нь хожмоо Монгол-Орос-Хятад гурван улсын түүх, улс төрийн бодлогыг харьцуулан судлах, харилцан хамаарлыг тодорхойлох чухал чиглэл болон төлөвшсөн байна.

1 “Орос дахь монгол угсааны улсууд”. УБ, 1995; Ч.Батцэцэг “ОХУ-ын БНБУ”. УБ, 1996

2 Б.Лхамсүрэн “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол.” УБ, 1995; Б.Балдоо, С.Дамдинсүрэн, Л.Хайсандай “Монголын тусгаар тогтнол ба Орос, Хятадын хүчин зүйл”. УБ, 1999; С.Дамдинсүрэн “Монголын тусгаар тогтнол: эрин зууны баталгаажилт”. УБ, 2001; К.Дэмбэрэл “Влияние международной среды на Монголию”. Иркутск, 2002; Б.Балдоо “Монгол Улсын гадаад харилцаа. XX зууны эхэн ба төгсгөл үе”. УБ, 2003; “Монголын улс төрийн гадаад харилцааны түүх.(1911-1919)” ШУА,ОУСХ, УБ, 2013

3 “Монгол - Оросын харилцаа: бүсчилсэн хөгжлийн бодлого, хамтын ажиллагаа”. Хамтын бүтээл, УБ, 2005; “ОХУ-ын бүс нутгаа хөгжүүлэх бодлого ба Монгол-Оросын харилцаа/(XX-XXI зууны заагт)”. Хамтын бүтээл. УБ, 2006

4 О.Батсайхан “Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээ” (1911 – 1916). УБ, 2002; “Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд” (1911-1946). УБ, 2005

*Орос судлалын чиглэлээр хэрэгжүүлсэн суурь судалгааны
төсөл, хамтарсан грант*

2010-2012 онд “Монгол орны гадаад орчны шинэчлэл: ОХУ, БНХАУ-ын хөгжлийн стратеги – 2020” сэдэвт судалгааны ажлыг (төслийн удирдагч доктор Sc.D О.Батсайхан) гүйцэтгэсэн байна. Төслийн явцад ОХУ, БНХАУ-ын хөгжлийн урт хугацааны буюу 2020 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх стратегийн баримт бичигт задлан шинжилгээ хийжээ. Тухайлбал, 2008 оны 11 дүгээр сард ОХУ-ын Засгийн газраас баталсан “ОХУ-ын 2020 он хүртэлх нийгэм-эдийн засгийн урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” баримт бичгийн үндсэн чиглэлүүд буюу Эдийн засаг, Гадаад бодлого, Инновацийн бодлого, Оросын нийгмийн бодлого зэрэг асуудлыг голлон судалсан байна. Мөн БНХАУ-ын 2020 он хүртэлх хөгжлийн стратегийн баримт бичгийг задлан шинжилсэн нь хөрш орнуудын хөгжлийн урт хугацааны бодлогын ижил төстэй ба ялгаатай талыг тодруулан гаргахад чиглэжээ. Энэ нь Монгол Улс хөгжлийн ойрын ба алсын зорилгоо оновчтой тодорхойлоход судалгааны шинэ мэдлэг, чухал хэрэглэгдэхүүн болох ач холбогдолтой юм. Энэ үеэс ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос ба Хятад судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд хамтран Суурь судалгааны ажлын сэдвийг хамтран боловсруулж, нэгдсэн нэг арга зүйг ашиглан гүйцэтгэдэг практик тогтсон. Хэдийгээр уг сэдэвт ажлын нэгдсэн тайлан хамтын бүтээл болж хэвлэгдээгүй ч, эрдэм шинжилгээний өгүүлүүд нь “Олон улс судлал” сэтгүүлд хэвлэгдэн гарсан байна.

2000 оноос Монгол-Оросын харилцаанд шинэ үе эхэлж, 2001 онд Монгол Улсын ШУА ба ОХУ-ын ШУА-ийн хооронд хамтран ажиллах тухай Санамж бичигт гарын үсэг зурсан юм. Энэ нь хоёр орны Академийн ижил төстэй Хүрээлэнгүүд хамтран ажиллах шинэ боломжийг нээсэн. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОХУ-ын Монгол судлалын гол төв болох Москва, Санкт-Петербург, Эрхүү, Улаан Үдийн Хүрээлэн, их дээд сургуультай харилцаа холбоог тогтоож, хамтран ажиллаж эхлэв. ОХУ-ын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны Сан, Монгол Улсын ШУТСангийн дэмжлэгтэйгээр ОХУ-ын ШУА-ийн Дорно Дахины Хүрээлэнгийн монголч эрдэмтэдтэй хамтран Монгол-Оросын харилцааны асуудлаар томоохон хамтын бүтээл туурвих саналыг дэвшүүлэн боловсруулж, тэдгээр нь хоёр удаагийн хамтарсан грантын гүйцэтгэлийн явцад амжилттай хэрэгжсэн. 1921-1990 он хүртэлх болон орчин үеийн Монгол-Оросын харилцааны төлөв байдлын тулгамдсан асуудлаар хоёр орны Орос ба Монгол судлаачдын бичсэн шинэлэг дүгнэлт хандлага бүхий хамтын бүтээлүүд⁵ 2001, 2011 онд тус тус хэвлэгдэн гарав. “Орос ба Монгол: XX зууны харилцааг шинэ өнцгөөс харахад”, “Орос ба Монгол Стратегийн түншлэлд хүрэх замд” нэртэй эдгээр хамтын бүтээлд анх удаа Монгол-Оросын харилцааны түүхийг бодит байдлаар задлан

5 .” Россия и Монголия: новый взгляд на взаимоотношения в XX веке”. Москва, ИВ РАН, 2001; “Россия и Монголия на пути к стратегическому партнерству”(1990-2005). Москва, ИВ РАН, 2011

шинжлэх, өмнө хаалттай байсан баримт бичгүүдийг судалгааны эргэлтэд ашиглах, нэг хүнийг тахин шүтэх явдлын хор уршиг, “их өр” зэрэг харилцааны ээдрээтэй асуудлыг нухацтай судлах бүтээлч эрэлхийлэл хийгдсэн ажээ.

Сибирийн Монгол судлалын төвүүд болох Эрхүү, Улаан-Үдийн монголч эрдэмтэдтэй идэвхтэй хамтын ажиллагааг өрнүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын БСШУЯ, ШУА-ийн Түүхийн хүрээлэн, ШУА-ийн Олон судлалын хүрээлэн, нөгөө талаас ОХУ-ын БШУЯ, Өвөр Байгалийн Эдийн засаг Бизнесийн Их Сургуультай хамтарсан төсөл хэрэгжүүлж, үр дүнгээр нь 2013 онд “XIX-XX зууны зааг үеийн Орос Монголын харилцаа: Эдийн засаг, Дипломат ёс, Соёл” нэртэй томоохон хэмжээний хамтын бүтээл гарав. Энэхүү хамтын бүтээлд XX зууны эхний 25 жилийн түүх, улс төр, дипломат ёс, эдийн засаг, соёл зэрэг олон чиглэлийг хамарсан судалгааны чамбай өгүүллүүд багтжээ. Үүний хоёр дахь ботид энэ үеийн түүхийн архивын баримт бичгүүдийг эмхэтгэн нэгтгэж хэвлүүлсэн байна.

ОХУ ын Буриад Улсын Байгалийн Их сургуулийн монгол судлаачидтай хамтран “Оросууд Монголд эргэж ирсэн нь: загвар ба төсөөллүүд” нэртэй грант төсөл хэрэгжүүлж, түүний үр дүнгээр 2013 онд “Орчин үеийн Монгол Оросын харилцаа: Загвар ба төсөөллүүд”⁶ хамтын бүтээлийг хэвлэн гаргалаа. Энэхүү бүтээл нь Монгол-Оросын харилцааны орчин цагийн төлөв байдалд шинэ арга зүйг ашиглан бодитой дүгнэлт хийж, олон талт эх сурвалжийг ашигласнаар сонирхолтой судалгаа хийгджээ.

2013-2015 онд тус хүрээлэнгийн Орос ба Хятад судлаач эрдэмтэд хамтран “Монгол Улс дахь Орос, Хятадын ашиг сонирхлын тулгамдсан асуудлуудын судалгаа (XX зууны эхэн үеэс одоо хүртэлх)” томоохон суурь судалгааг (төслийн удирдагч доктор Ph.D Д.Шүрхүү) гүйцэтгэсэн. Судалгааны эхний үр дүнгээр 2015 онд өгүүллийн эмхэтгэл⁷ хэвлэгдэн гарав. Энэ судалгаа нь Монгол Улсын гадаад орчны асуудлыг хөрш хоёр орны бодлого, хандлага, байр суурийн солбицолд харьцуулан судлах шинэ хандлагыг баримталснаар ихээхэн онцлогтой байв. Ингэснээр Монгол Улс ойрын ирээдүйн гадаад бодлогоо тодорхойлоход хөрш хоёр улстай өнгөрсөн хугацаанд харилцаж ирсэн бодлого, үйл ажиллагааны алдаа оноо, түүхэн сургамжаас ухаарал авч, шүүн тунгаах чухал дүгнэлт, зөвлөмжийг боловсруулжээ. Даяаршилын өнөө үед олон улсын харилцаа, тухайн улсын гадаад орчинд гарч буй өөрчлөлтүүдийг цаг тухайд нь хурдан мэдэрч, улс орны гадаад дотоод бодлогодоо тусгах нь чухал шаардлага болж байна.

2015-2017 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлаачид ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн болон Эрхүү, Улаан-Үдийн монголч эрдэмтэдтэй хамтран “Монгол-Оросын харилцааны нэвтэрхий толь (XVII зуунаас одоо хүртэл)” хамтарсан грант төслийг (төслийн удирдагч доктор Ph.D Е.Бойкова, доктор Ph.D Д.Шүрхүү) амжилттай хэрэгжүүлэв. Төслийн гүйцэтгэлийн явцад

6 “Современные российско-монгольские отношения модели и сценарии”. БГУ, Улан-Удэ, 2013

7 “Стратегийн түншлэл ба Монголын гадаад орчны өөрчлөлт (Өгүүллийн эмхэтгэл)”. ШУА, ОУХХ, УБ, 2015

ХҮШ зууны хоёрдугаар хагасаас ХХI зууны одоо үе хүртэлх 400 гаруй жилийн хугацаанд Монгол-Оросын харилцаанд хамааралтай түүхэн үйл явдал, хувь хүн, гэрээ хэлэлцээр зэрэг хоёр улсын харилцааны баримт бичгүүд, нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарсан онцлог үйл явдал, мэдээ, мэдээлэл, тодруулга лавлагаа бүхий олон зуун нэр томьёоны бичил тайлбарыг боловсруулан бичжээ. Энэхүү толь бичиг нь ОХУ-ын Суурь судалгааны Сангийн дэмжлэгтэйгээр Москва хотноо орос хэлнээ 2022 онд хэвлэгдэн гарна. Урьд өмнө хоёр орны харилцаанд хамааралтай олон тооны үйл явдал, мэдээ лавлагааг нэг дор багтаасан хамтын бүтээл гарч байгаагүй бөгөөд Монгол-Оросын харилцааны түүхийн уг сурвалжаас эхтэй олон тооны үйл явдал, мэдээ, мэдээллийн нэгдсэн цомог болж байгаагаар бүтээлч шинэлэг судалгаанд зүй ёсоор тооцогдож байна.

2017-2019 “Хүйтэн дайнаас хойших Монгол, Орос, Хятадын гурамсан харилцаа (1990-2018) төслийг (удирдагч доктор Sc.D Ж.Баясах) ШУТС-ийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн байна. Энэ төслийн хүрээнд Монгол-Оросын харилцааны улс төр, эдийн засаг, нийгэм-соёл, шинжлэх ухаан боловсролын салбарын харилцаа, хамтын ажиллагааны хөгжил, түүний шинэлэг агуулга хэлбэрийг судлан гаргажээ. Хоёр орны харилцааны эрх зүйн үндэс болсон хамтын ажиллагааны баримт бичгүүдийг тоймлон гаргаж, иж бүрэн стратегийн түншлэлийн хэлбэрт дэвшсэн түүхэн замнал, харилцааны хөгжилд тулгарч буй сорилт бэрхшээл, ахиц ололтыг задлан шинжилж, өмнөх үеийн Монгол-Оросын харилцаанаас зарчмын ялгаатай байдлыг тодорхойлон гаргахыг эрмэлзжээ. 1990 оноос хойших орчин цагийн шатанд Монгол-Оросын харилцааг цогц байдлаар өөрчлөгдөн хөгжиж ирсэнийг Монгол-Хятадын харилцааны хөгжил дэвшил, ололт амжилт, сорилтуудтай харьцуулан судалж, Монгол, Орос, Хятадын гурван талт хамтын ажиллагааны механизм бүрэлдэн хөгжиж буй асуудлыг авч үзсэнээр шинэлэг сонирхолтой судалгаа болсон.

2019-2021 онд ОХУ-ын Суурь судалгааны сан, Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн сангийн дэмжлэгээр ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОХУ-ын Байгалийн улсын их сургуультай багш, судлаачдын баг хамтран “Монгол, Орос, Хятад гурван улсын эдийн засгийн коридор дахь үндэсний ашиг сонирхол: асуудал, зөрчил, хувилбарууд” грант төслийг (удирдагч доктор Sc.D Ж.Баясах, доктор Sc.D Ю.Кузьмин) хэрэгжүүлж дууссан. Энэ судалгаа нь өнөөгийн шатанд хөрш гурван орны нийгэм эдийн засгийн хөгжилд практик ач холбогдолтой байгаа Эдийн засгийн коридорын асуудлыг улс тус бүрийн ашиг сонирхол, түүнийг харгалзан эдийн засгийн үр өгөөжийг хамтдаа яаж хүртэх вэ гэсэн сонирхолтой солбицолд шинжилсэнээрээ онцлог судалгаа болсон.

2019-2021 онд ОХУ-ын Суурь судалгааны сан, Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн сангийн дэмжлэгээр ОХУ-ын Улаан-Үдийн Буриадын их сургууль, ШУА-ийн ОУСХ-гийн судлаачдын баг хамтран “Монгол–Оросын харилцаан дахь «зөөлөн хүч»-ний бодлого” грант төслийг (удирдагч доктор Ph.D А.Нямдолжин, доктор Ph.D В.Родионов) хэрэгжүүлж байна. Сүүлийн үеийн судалгаанд түгээмэл ашиглаж буй ”зөөлөн хүч”-ний бодлогыг Монгол-Оросын

харилцааны хүмүүнлэгийн салбарын харилцан хамаарлын сэдэвт багтаан задлан шинжлэх нь хоёр орны иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны бүрэлдэхүүн агуулгыг тодруулахад чухал ач холбогдолтой юм. Судалгаанаас гарах зарчмын санаа оноо, дүгнэлт нь хоёр орны бие биенээ сонирхох хандлагыг идэвхжүүлэх, хамтын ажиллагааны шинэ хэлбэрийг эрэлхийлэхэд шинэ мэдлэг хуримтлуулах ач холбогдолтой юм.

2020 онд Монгол Улсын ШУА-ийн Ерөнхийлөгчийн захиалгаар ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОХУ-ын Новосибирск хот дахь ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Эдийн засгийн хүрээлэнтэй хамтран “Зүүн Хойд Азийн орон зайн хөгжил: стратегийн тэргүүлэх чиглэл, инноваци ба интеграци” сэдэвт Монгол, Орос, Хятад улсын эрдэмтдийн хамтарсан ном туурвих грант төслийг хэрэгжүүлж байна. Хамтарсан төслийн гүйцэтгэгчээр Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын судлаач эрдэмтэд хамтран ажилласан. Монголын талын зохицуулагчаар ШУА-ийн ОУСХ-гийн салбарын эрхлэгч, доктор (Sc.D) А.Даваасүрэн ажиллав. Уг төслийн тайланг Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан Улаан-Үд хотноо 2021 оны 09-р сарын 10-ны өдөр зохион байгуулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын үеэр уг төслийн Оросын талын захиалагч болох Оросын ШУА-ийн Сибирийн салбарын дарга, доктор А.Пармонд гардуулан өгсөн байна. 2022 онд энэхүү хамтын бүтээл нийтийн хүртээл болж хэвлэгдэнэ.

2021-2023 онд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтнууд “Путины засаглалын үеийн ОХУ-ын гадаад бодлого ба түүний Монгол Улс дахь тусгал” гэсэн томоохон суурь судалгааны төслийг хэрэгжүүлж эхлэв. Төслийн удирдагчаар түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D) О.Батсайхан ажиллаж байна.

Орос судлалын салбарт хэрэгжсэн Суурь судалгааны төсөл, хамтарсан грант, захиалгат судалгаа нь Монголд Орос судлалыг орон судлалын агуулга, үндсэн чиглэлээр амжилттай хөгжүүлэхэд чухал хэлбэр, үр ашигтай механизм болж буйг харуулж байна. Судалгааны үр дүн нь хамтын зохиол бүтээлд тусгагдаж буй нь сайшаалтай. Зарим төслийн эцсийн тайлан хамтарсан нэг сэдэвт бүтээл болон хараахан гараагүй байгаа байдалд цашид анхаарч, тэдгээрийг бодлогын зөвлөмж, санал дүгнэлтийн хамт хэвлэж, олны хүртээл болгох нь судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал юм.

Монгол-Оросын харилцааны асуудал агуулга, хэлбэрийн хувьд өргөжиж, урьд өмнө бага судлагдсан асуудлыг шинээр судалгааны эргэлтэд оруулах, хоёр орны эдийн засгийн харилцааны чиглэлийг бүс нутгийн хөгжлийн хамтын ажиллагаа, Эдийн засгийн коридор зэрэг асуудлаар өргөжүүлсэн зэрэг давуу тал харагдаж байна. Мөн түүхэн урт хугацааг хамарсан Монгол-Оросын харилцаанд хамаарах олон талт үйл явдлын тайлбар, лавлагааны толь бичиг туурвих, Монгол-Оросын харилцааны 100 жилийн түүхэн товчоон зэрэг шинэ хэлбэрийн судалгааг санаачлах, нийгэм-хүмүүнлэгийн салбарын сэдэвт анхааран судалгаа эхлүүлэх зэрэг нийгмийн амьдралын олон талт асуудлыг хамарсан цогц судалгааны суурийг

амжилттай эхлүүлж байна.

2000 оноос хойших Орос судлал бие даасан салбарын хэмжээнд орон судлалын үндсэн агуулга, чиглэлийг удирдлага болгон нээлттэй, чөлөөт байдлаар хөгжиж, үзэл сурталжсан хандлагаас ангижирч чадсан байна. Орос судлаачдын мэргэшсэн хүний нөөц бий болж, орос судлалын тодорхой асуудлаар судалгаа хийх эрдэм шинжилгээний байгууллагуудын хүрээ өргөжив. Мөн нийгмийн шинжлэх ухааны шинэ арга зүй, хандлагыг нэвтрүүлэх, олон талт эх сурвалжид бодит дүн шинжилгээ хийх зэрэг дэвшилтэт хандлага судалгаанд нэвтэрч буй нь сайшаалтай.

*Орос судлалын нэг сэдэвт болон
хамтарсан зохиол бүтээлийн тойм:*

Монгол-Оросын харилцааны орчин үеийн шатны хөгжлийн агуулга, онцлог, төлөв байдлын асуудлаар бие даасан судалгаа хийгдэж нэг сэдэвт зохиол бүтээл гарч байгаа нь олзуурхууштай. Тухайлбал, Х.Мандухай “Монгол-Оросын харилцаа (1990-2012 он)”. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, УБ, 2014, 80 хууд.; А.Нямдолжин. Монголо-российские отношения на современном этапе (1990-2004 гг.). Санкт-Петербургский Университет, УБ, 2016, 143 с.; Д.Алтай “Хөршийн харилцаа, Орос-Европ судлал (Өгүүлэл, илтгэл, ярилцлага)”. Монгол Улсын ШУА, ОУХХүрээлэн, УБ, 2020, 344 хуудас. зэрэг бүтээл хэвлэгджээ.

1990 оноос хойш одоо үе хүртэлх Монгол-Оросын харилцаанд хамаарах баримт бичгийн эмхэтгэл хоёр ботиор хэвлэгдэн гарсан байна. Эхний боть нь 2005 онд “Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд (1991-2004)” нэртэй хэвлэгдсэн бол 2 дахь нь 2020 онд олны хүртээл болсон. Ингэснээр орчин үеийн шатны Монгол-Оросын харилцааны эрх зүйн үндэс болсон бүхий л баримт бичгүүд судлаачдад бүрэн нээлттэй болж, судлаачдад чухал сурвалж хэрэглэгдэхүүн болов. Сүүлийн үеийн ном зохиолоос дурьдвал Монгол Улс, ОХУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тохиолдуулан “Монгол-Оросын харилцаа бичгүүд (2004-2020)”, эмхэтгэгч Д.Туул, ред.О.Батсайхан, ШУА, ОУСХ, УБ, 2021, 438 хууд.; “Монгол ба Оросын харилцаа: он дарааллын товчоон” ШУА, ОУСХ, УБ, 2021, 655 хууд. зэрэг томоохон бүтээлийг ОУСХ-гийн Орос судлалын салбараас эрхлэн гаргажээ.

Дээр дурдсан ном зохиолын сацуу олон арван эрдэм шинжилгээний өгүүллүүд ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Дорно дахин судлалын хүрээлэн, Зүүн хойд Ази судлалын төв зэргээс эрхлэн гаргаж байсан “Дорно дахины асуудал”, “Өрнө–Дорно”, “Зүүн хойд Ази судлал”, “Олон улс судлал”, “Пакс Монголика” зэрэг сэтгүүлд нийтлэгдсэн байдаг. Тэдгээрт Орос судлалын “хаалттай”, “эмзэг” сэдвийг хөндөж зарим шинэ чиглэл, сэдвийг судлах оролдлого хийгдсэн нь өнөөдөр ч ач холбогдлоо алдаагүй, залуу судлаачдын сонирхлыг татсан хэвээр байна. Тухайлбал, Монгол-Оросын эдийн засгийн хамтын ажиллагаа, Монгол–Оросын харилцааны түүх, түүний үе шат ба онцлог, сталинизм ба сүм хийдийн асуудал, Монгол-Тувагийн харилцаа зэрэг олон өгүүллийг нэрлэж болно.

Орос судлалтай холбоотой бусад үйл ажиллагаа

Сэтгүүл: 2006 оноос ШУА-ийн ОУСХ-гийн Орос судлалын салбар “**Эв мод**” (“**Древо единства**”) тусгай сэтгүүлийг гаргасан байна. Нийт 6 дугаар гарсан энэхүү сэтгүүлд ОХУ-ын аж байдал, Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагаа, Орос судлалын чиглэлээр танин мэдэхүйн болон эрдэм шинжилгээний зарим өгүүлүүд орсны сацуу хоёр орны амьдралд гарсан шинэлэг мэдээ мэдээлэл, лавлагаа тойм, тайлбар өгүүлэл, гэрэл зураг хэвлэгдэж байжээ. Энэ сэтгүүлийг бэлтгэн гаргахад ОУСХ-гийн Орос судлалын салбарын судлаач, доктор (Ph.D) К.Дэмбэрэл идэвх санаачилгатай ажилласан байна. 2013 онд Төв Зүүн Европ судлалын Монголын Холбоо санаачлан ШУА-ийн ОУСХ-тэй хамтран “**Центральная и Восточная Европа**” сэтгүүлийг орос хэлээр хэвлэн гаргав. Уг сэтгүүлийн агуулга нь Монгол-Оросын харилцаа, хамтын ажиллагааны сэдэвт зориулагдсан ба Олон улсын харилцаа, Эдийн засаг, Хэл шинжлэл ба соёл чиглэлээр 10 гаруй судлаачид, МУИС-ийн багш нарын өгүүлэл багтжээ.

Орос судлал олон улсын сүлжээнд нэгдсэн нь:

2012 онд ШУА-ийн ОУСХ-гийн дэргэд Төв болон Зүүн Европ судлалын Монголын Холбоо ТББ байгуулагдаж, Олон Улсын Холбоонд (ICCEES-International Council for Central and Eastern Europe studies) 2013 онд гишүүнээр элссэн. Тус байгууллага 1974 онд байгуулагдсан ба Слав-Еврази судлалын Зүүн Азийн эрдэм шинжилгээний бага хурлыг жил тутам, их хурлыг 5 жилд нэг удаа зохион байгуулдаг бөгөөд Монголын төлөөлөгчид 2013 оноос хойш тасралтгүй 6 удаагийн бага хурал, 2 удаагийн их хуралд оролцож, илтгэл хэлэлцүүлжээ. Монголын Орос судлаачид дэлхийн нэр хүндтэй сүлжээ байгууллагад элссэнээр гадаад харилцаагаа шинэ түвшинд хөгжүүлэх, дэлхийн Орос судлал эдүгээ ямар түвшинд хөгжиж буйтай танилцах, орчин үеийн судалгааны арга барил, хандлага, туршлагаас бүтээлчээр суралцах боломжтой болсон. 2018 онд Слав-Еврази судлалын Зүүн Азийн олон улсын эрдэм шинжилгээний 9-р бага хурлыг ТЗЕСМХ ТББ хариуцан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан нь тус холбооны нэр хүндийг олон улсын тавцанд өсгөхөд чухал ажил болсон байна. 2021 оны 8-р сард тус Холбооны тэргүүн, доктор (Ph.D), профессор Д.Алтай ICCEES олон улсын байгууллагын Гүйцэтгэх Хорооны гишүүнээр сонгогдон Монгол Улсаа төлөөлөн ажиллаж байна. Тус Холбоо нь 2013 оноос Төв, Зүүн Европ судлалыг Монголд хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Central and Eastern Europe” нэртэй сэтгүүлийг англи, монгол хос хэлээр хэвлэн гаргаж байна. Эдүгээ тус сэтгүүлийн нийт 6 дугаар хэвлэгджээ.

Орос судлалыг Монголд хөгжүүлэх санал санаачилга:

ШУА-ийн ОУСХ-гийн удирдлага Монгол, Орос, Хятад гурван орны эрдэмтдийн чуулганыг зохиох санаачилга гарган, анхны уулзалтыг 2008 онд Улаанбаатар хотод зохион байгуулжээ. Энэ санаачилгыг хөрш хоёр орон дэмжиж, хоёр дахь уулзалтыг 2009 онд Бээжинд, гурав дахь уулзалтыг нь 2011 онд Москвад тус тус зохиосон байна. Гурван орны эрдэмтдийн хамтын ажиллагааны энэхүү механизм нь судлаачид туршлага, мэдээллээ харилцан солилцох чухал индэр болж байв. 2013 онд дөрөв дэх чуулган нь “Ногоон хөгжил – XXI зууны гурван талт хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл” сэдвээр Улаанбаатар хотноо дахин болсон. Харин 2014 онд Бээжин хотноо 5 дахь чуулган нь “Зүүн Хойд Азийн хамтын ажиллагааны хэтийн төлөв” сэдвээр хуралдсан. Гурван талт хамтын ажиллагааны энэхүү механизм хожим Эдийн засгийн коридор байгуулах хамтын хүчин чармайлтад тус дөхөм үзүүлэх гурван орны эрдэмтдийн Тинк Танк Зөвлөлдөх танхим хэлбэрээр үргэлжлэх суурь нөхцөл болсон.

2013 онд ШУА-ийн ОУСХүрээлэн “Орос судлалыг хөгжүүлэх Үндэсний Хөтөлбөр” боловсруулан Хүрээлэнгийн 2013-2015 оны Стратеги төлөвлөгөөнд тусган бодлого үйл ажиллагаанд анхааран ажиллаж байжээ.

2015 онд “Нэг Бүс-Нэг Зам” БНХАУ-ын санаачлагын хүрээнд Орос, Монгол, Хятад гурван орны эрдэмтэн судлаачдын Зөвлөлдөх танхимын (Think Tank) чуулга уулзалтын механизм бүрэлдэн хөгжив. Эхний уулзалт нь 2015 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо хуралдсан бол удаах нь 2016 онд БНХАУ-ын Хөх хотод, гурав дахь нь 2017 онд ОХУ-ын Улаан-Үд хотод, 2018 онд дөрөв дэх нь Улаанбаатарт тус тус зохион байгуулагдсан. ОХУ болон БНХАУ-ын хоорондын стратегийн түншлэл эрчимтэй хөгжиж, бусад улс орнуудад үлгэр дууриал болж буйг олон улсын шинжээчид тэмдэглэдэг. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ”⁸ гэж заасан байдаг. Эдүгээ гурван орны эрдэмтэн судлаачдын чуулган нь Эдийн засгийн коридор байгуулах зорилттой нягт уялдан тогтмол зохион байгуулагддаг арга хэмжээ болж, судлаач харилцан мэдлэг мэдээлэл, туршлага солилцох чухал индэр болсон. Гурван орны эрдэмтэн судлаачдын хамтын оролцоотой судалгааны нэг сэдэвт хамтын бүтээл туурвих, бодлогын зөвлөмж боловсруулан практикт нэврүүлэх зэрэг бодитой үр дүн чуулганаас гарах болсон. Энэхүү механизм нь гурван орны хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг шинэ агуулгаар хөгжүүлэн Монгол Улсаас ОХУ ба БНХАУ-тай тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны үзэл санааг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болж байна.

8 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сайт www.legalinfo.mn/annex/details (2021.12.17-д хандсан)

Гурав. Монгол дахь Орос судлалын хэрэгцээ, тулгамдсан зорилт

Орос судлалыг эрчимжүүлэх эрэлт хэрэгцээ, шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Нэг талаас, ОХУ нь НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн гишүүний хувьд олон улсын харилцаанд эзлэх байр суурь, дэлхийн бодлогод үзүүлдэг нэр нөлөө, хандлагаар чухал тоглогч их гүрнүүдийн нэг бөгөөд манай оронтой өргөн уудам нутгаар хиллэдэг хөрш орон. 2000 оноос ОХУ нь Ази, Номхон далайн бүс нутагт харьцангуй бага анхаарч ирсэн байдлаа өөрчилж, гадаад бодлогоо энэ чиглэлд эрчимжүүлсэн. 2014 онд Крымыг Орост нэгтгэсэн үйл явдлаас улбаалан АНУ болон барууны өндөр хөгжилтэй орнууд Орост улс төр-эдийн засгийн цуврал хориг тавьж, дарамт шахалт үзүүлж, Оросыг ганцаардуулах бодлогыг баримтлах болов. Ийм нөхцөлд ОХУ нь БНХАУ-тай харилцаагаа нягт уялдуулан зохицуулах арга тактикт шилжив. Мөн Энэтхэг, Турк зэрэг бусад улс орнуудтай харилцаагаа өргөжүүлэх бодлого явуулж байна. 1989 оноос хэвийн болж эхэлсэн Орос-Хятадын найрсаг харилцаа нь Стратегийн түншлэлийн түвшинд хүрч өргөжин, хоёр орны худалдааны эргэлт жил тутам хурдацтай нэмэгдэх болов. Орос-Хятадын харилцааны энэхүү ойртолт нь Монгол Улсын хувьд ямар сорилтыг авчрах вэ, Монгол Улс хөрш хоёр орны аль алинтай нь харилцахдаа өөрийн ашиг сонирхлыг хэрхэн хамгаалж, гурван талт хамтын ажиллагааны механизмд яаж оролцох вэ зэрэг асуудал Монгол Улсын хувьд тулгамдсан зорилт болов.

2009 оноос Монгол Улс ОХУ-тай анхлан стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон ба уг зорилт амьдралд бүрэн дүүрэн хэрэгжиж амжаагүй хэдий ч 2019 онд байгуулсан “Найрсаг харилцаа, иж бүрэн харилцаа стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ” нь хоёр талын харилцааг чанарын шинэ түвшинд гарган, уг гэрээг хугацаагүй хэрэгжихээр баталгаажуулсан. 2021 оны 12 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Москвад айлчилж Москвагийн Тунхаглалыг баталсан нь хоёр орны олон талт харилцааг илүү идэвхтэй хэлбэрт шилжүүлэх, практик үр дүнг дээшлүүлэхэд чухал түлхэц үзүүлэв.

Түүнчлэн, Монгол-Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд шинэ хуудас болж буй ОХУ-аас БНХАУ-д байгалийн хий нийлүүлэх хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан барих төслийн ажил амжилттай хэрэгжиж эхэлсэн нь Монголын хувьд Оросын талаар баримтлах бодлогоо эдийн засгийн агуулгаар баяжуулахад чухал хүчин зүйл болж байна.

Москвагийн Тунхаглалд “Монгол Улсад Орос судлал, ОХУ-д Монгол судлалыг хөгжүүлэхэд анхаарч ажиллана” гэж онцлон заасан нь Орос судлалыг эрчимжүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээг шинэ агуулгаар нөхцөлдүүлж байна.

ОХУ-д сүүлийн жилүүдэд Монгол судлал шинэ агуулга хэлбэрээр баяжин хөгжиж буй нь ОХУ-д зохиогдож буй эрдэм шинжилгээний бага хурал, хэрэгжүүлж буй судалгааны төслүүд, монголч эрдэмтдийн зохиол бүтээлээс

тодорхой харагдаж байна.

Нөгөө талаас, хойд хөрштэйгээ зөв зохистой харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх алсын хараатай ухаалаг бодлого стратегийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж чадваас Оросын асар том зах зээл, газар зүйн ойр байршил гэх мэт давуу талаа хөгжлийн чухал хүчин зүйл болгох гарц Монголын хувьд нээгдэх юм. Иймээс ОХУ-ын зах зээлийн эрэлт хэрэгцээ, ялангуяа Алс Дорнод, Сибирийн бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх Оросын дотоод бодлогын мөн чанарыг судлах, Монголын ашиг сонирхолтой хэрхэн уялдуулж болох гаргалгааг нарийвчлан тооцох нь чухал зорилт болж байна.

Энэ бүх байдлаас дүгнэн үзвэл Орос судлалыг шинэ шатанд гарган хөгжүүлэх тулгамдсан зорилтууд дэвшигдэж байна. Үүнд:

- “Орос судлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, практик хэрэгцээнд тулгуурлан тодорхой асуудлыг эрэмбэлэн ээлж дараатай судлах, тэдгээрийн үр дүн, практик зөвлөмжийг төрийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд зохистой ашиглах механизм бий болгох
- Орон судлалын хувьд бага судлагдсан зарим сэдвийг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах, судалгаанд орчин үеийн арга зүй, шинэлэг хандлагыг нэвтрүүлэх, хэвшиж тогтсон “хөрш орны” хэмжүүрээс татгалзах
- Төр засаг, судалгааны байгууллагын харилцан ойлголцол, эргэх холбоо, удирдлага менежментийг сайжруулах, судалгааны санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэх зорилгоор дотоод, гадаад түнш олж авахад шинэлэг арга барил сэтгэлгээ, орчин үеийн менежментийг нэвтрүүлэх
- Орос судлалын мэргэшсэн хүний нөөц хязгаарлагдмал тул Орос судлалыг эрхэлж буй сургалт судалгааны байгууллагуудын ажлын уялдаа холбоо, дагнан мэргэших асуудлыг яаралтай зохицуулах, цаг хугацаа, хөрөнгө, хөдөлмөр хэмнэж тодорхой чиглэлд хүч анхаарлаа төвлөрүүлэх
- Орос судлалаар залгамж халаа, мэргэжилтнийг бодлогоор үе шаттай сургаж бэлтгэх, туршлагатай судлаачдыг дагалдуулах ментор хөтөлбөрийг хэрэгжүүлэх, залуу судлаачдад тэтгэлэг олгох, тэдэнд бусад төрлийн дэмжлэг үзүүлэх
- Орос судлалаар мэргэшсэн гадаад орны судалгааны хүрээлэн, төвүүдтэй харилцаа холбоог өргөжүүлэн хөгжүүлэх, мэдээлэл, туршлага солилцох зорилгоор Монголын орос судлаачдыг ОХУ болон бусад оронд томилолтоор зочин судлаачаар ажиллуулах

Хөрш их гүрнүүдтэй тэнцвэртэй харилцахад ашигтай харилцаа, алсын хараатай бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хөрш орон судлалыг хөгжүүлэх, энэ салбарын эрдэмтэн судлаачдын дорвитой бүтээл, мэргэн зөвлөмж, үнэтэй зөвлөгөө чухал үүрэг гүйцэтгэдэг тул Орос судлалын өнөөгийн хүрсэн түвшинд тулгуурлан дээрх тулгамдсан зорилтыг цаг алдалгүй ажил хэрэг болгох нь чухал болж байна.

Ном зүй:

1. "Орос судлал тулгамдсан асуудлууд, хэтийн төлөв" Эрдэм шинжилгээний бага хурал. 2016-12.05. Илтгэлүүдийн эмхэтгэл, хурлын материал. МУИС, ОУХНУС, ШУС, УБ, 2016, 99 х.
2. "Монголия: история, вызовы XX века, перспективы. Сборник научных статей". ИВ РАН, Институт Истории и Археологии МАН, Институт Социологии РАН, УБ, 2017, 251 с.
3. А.Нямдолжин "Монголо-российские отношения на современном этапе (1990-2004 гг.)." Санкт-Петербургский Государственный Университет, УБ, 2016, 143 с.
4. Олон улсын харилцааны хүрээлэн: Хагас зууны түүхэн товчоон (1968-2018). Монгол Улсын ШУА, ОУХХ, УБ, 2018 он, 320 хууд.
5. Д.Алтай "Хөршийн харилцаа, Орос-Европ судлал (Өгүүлэл, илтгэл, ярилцлага)". Монгол Улсын ШУА, ОУХХүрээлэн, УБ, 2020, 344 хууд.